



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

*MONTHLY BULLETIN OF STATISTICS*

2016/12



[www.nso.mn](http://www.nso.mn) [govisumber.nso.mn](http://govisumber.nso.mn) [www.1212.mn](http://www.1212.mn)



## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл .....	
Аргачлалын тайлбар.....	
I.Нийгмийн байдал.....	
II. Нийгмийн даатгал, халамж.....	
III.Эрүүл мэнд .....	
IV.Гэмт хэрэг .....	
V.Үнэ.....	
VI.Төсөв.....	
VIII.Хөдөө аж ахуй .....	
VIII. Аж үйлдвэр .....	
IXI.Тээвэр.....	
XI. Холбоо.....	
XII.Цаг агаарын мэдээ.....	
Хавсралт.....	



## Ерөнхий тэмдэглэл

### I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

### II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

### III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй\* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### • Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

### • Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.



✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.



- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын Тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул, хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



## Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны эхний 12 сарын байдлаар)



### I. Нийгмийн байдал

#### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 12 сард 238 байгаагийн 130 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 94 буюу 71.7 хувиар буурч өмнөх сарынхаас 19 буюу 8.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эхний 12 сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 151 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх сараас 37 буюу 32.5 хувиар өссөн, өмнөх оны мөн үеэс 3.5 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр халамж, үйлчилгээний газраар 49 иргэн ажилд зуучлуулсны 29 нь буюу 59.2 хувь эмэгтэйчүүд байлаа. Ажилд зуучилсан иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6.1 дахин буурсан ба өмнөх сартай харьцуулахад 40 хувиар өссөн байна.

Зураг. I.1

Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй, жил бүрийн эхний 12 дугаар сарын байдлаар



Ажил хайгч иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 45, 25-34 насны 90, 35-44 насны 60, 45-54 насны 36, 55- аас дээш насны 7 иргэн байна.




## I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны жилийн эцсийн байдлаар 459 эх амаржиж, 465 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 24 буюу 5.5 хувиар, төрсөн хүүхдийн тоо 24 буюу 5.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн нас баралт 115, бүртгүүлсэн гэр бүл 81, цуцалсан гэр бүл 20, үрчлэгдсэн хүүхэд 7 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс нас баралт 25 буюу 27.8 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 3 буюу 3.8 хувиар тус тус өсч, цуцалсан гэр бүлийн тоо өмнөх оны мөн үеэс 4 буюу 16.7 хувиар буурч, үрчлэгдсэн хүүхдийн тоо өмнөх оны мөн үетэй ижил үзүүлэлттэй байна.

Зураг.I.2

Төрсөн хүүхдийн тоо, жилийн эцсийн байдлаар



## II. Нийгмийн даатгал, халамж

### II.1 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эцсийн байдлаар 7583.6 сая төгрөг, зарлага 9385.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 898.5 сая төгрөг буюу 13.4 хувиар, зарлага 784.7 сая төгрөг буюу 9.1 хувиар тус тус өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 7.0 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 23.8 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 20.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өсөхөд тэтгэвэрийн сангийн зарлага 10.3 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 13.2 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 9.3 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.



## II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 онд 4724 хүнд 1259.7 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 216 хүн буюу 4.8 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 34.4 сая төгрөг буюу 2.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2016 онд 1526 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 42 хүн буюу 2.8 хувиар, 814.5 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосон нь 30.1 сая төгрөг буюу 3.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2016 онд 3198 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 174 хүн буюу 5.8 хувиар, 445.2 сая төгрөгийн халамж үйлчилгээ хөнгөлөлт, тусламж олгосон нь 4.4 сая төгрөг буюу 1.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


## II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 12 сарын мэдээгээр 197 байгууллагын 5952 даатгуулагч иргэн, үүнээс 1058 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуулагчдын цалин өссөн дүнгээр 39225.1 сая төгрөг байгаа бол сарын дундаж цалин сайн дурын даатгуулагч ороогүй дүнгээр 645.0 мянган төгрөг байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 21 аж ахуйн нэгж, байгууллагын 1263 ажилтны дундаж цалин нь 952.6 мянган төгрөг, төсөвт 57 байгууллагын 1750 ажилтны дундаж цалин нь 732.7 мянган төгрөг, 7 ХКомпанийн 690 ажилтны дундаж цалин нь 1233.4 мянган төгрөг, 90 ХХКомпанийн 969 ажилтны дундаж цалин нь 391.9 мянган төгрөг, бусад 22 байгууллагын 222 ажилтны дундаж цалин нь 338.0 мянган төгрөг боллоо.

Зураг II.1

Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2016 оны жилийн эцсийн байдлаар








### III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны жилийн эцсийн байдлаар 446 эх амаржиж, 2015 оны мөн үетэй харьцуулахад 4 буюу 0.9 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 450 үүнээс 222 нь хүү, 228 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амьд төрсөн хүүхэд 4 буюу 0.9 хувиар өссөн байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Зураг III.1




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7 ба 1000 амьд төрөлтөд 15.5 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 промиллоор нэмэгдсэн, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

Халдварт өвчин жилийн эцсийн байдлаар 292 буюу 10000 хүн амд 175 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 177 тохиолдлоор нэмэгдэж, нийт өвчлөлд улаан бурхан өвчин нь 47.9 хувийг эзэлж байна.

Зураг III.2

Нас баралт, жилийн эцсийн байдлаар






Он гарсаар 122060 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2327 буюу 1.9 хувиар, 5023 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 455 буюу 10.0 хувиар тус тус өссөн байна.

2016 оны байдлаар түргэн тусламжийн дуудлага 6927, халдварт өвчин 292 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Амьгүй төрөлт болон нялхасын эндэгдэл,  
жилийн эцсийн байдлаар




#### IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 онд 207 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 буюу 1.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо,  
жилийн эцсийн байдлаар






Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд 30.7-31.5 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэргийн тоо 23 болж өмнөх оны мөн үеэс 8 хувиар суурлаа. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 76.5 болсон өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 175 хүн гэмтэж, 29 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 69 буюу 28.3 хувиар буурч, нас барсан хүний тоо 7 буюу 31.8 хувиар өссөн байна.

Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал,  
жилийн эцсийн байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 онд 472 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 306 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 2.5 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 163 сая төгрөг буюу 65.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2016 онд 877 хүн эрүүлжүүлэгдэж, 18 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 273 буюу 23.7 хувиар, баривчлагдсан хүний тоо 122 хүнээр буюу 7.7 дахин багассан байна.



Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо  
жилийн эцсийн байдлаар



#### V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.3 пунктээр, өмнөх оны мөн үеийнхээс 3 пунктээр тус тус өссөн байна.

#### Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 12 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2016. XII	2016. XII
	2015. XII	2016. XI
Ерөнхий индекс	103.0	101.3
Хүнсний бараа, ундаа, ус	101.5	104.4
Согтууруулах ундаа, тамхи	101.1	98.4
Хувцас, бөс бараа, гутал	105.6	100.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	106.7	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.4	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.0	100.0
Тээвэр	97.3	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	97.8	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	124.9	100.0
Бусад бараа, үйлчилгээ	101.4	100.0



## VII. Орон нутгийн төсөв


2016 оны байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 15036.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 15701.4 сая төгрөг болж орлогын төлөвлөгөө 104.4 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 16828.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 14687.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 2141.0 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

2016 оны байдлаар авлагын үлдэгдэл 12.3 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 27.9 сая төгрөг байна.

Зураг VI.1

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жилийн эцсийн байдлаар, сая төгрөгөөр



## VIII. Мал аж ахуй


Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлтэгч малын 157213 буюу 91.8 хувь нь төллөсөн байна. Эм хонины 94.4 хувь, эм ямааны 89.2 хувь, үнээний 96.7 хувь, ингэний 68.8 хувь, гүүний 89.4 хувь нь төллөсөн бөгөөд 2016 оны жилийн эцсээр 153066 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 13331 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Төл бойжилт 97.4 хувьтай байна.

2016 онд том малын зүй бус хорогдол 14686 болж, өмнөх оны мөн үеийнхээс 7.4 дахин өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 38 мал, хорогдсон хээлтэгч 5468 байна.




Зураг VIII.1

## Төл бойжилт, жилийн эцсээр, толгойгоор



Зураг VIII.2

## Хорогдсон хээлтэгч, жилийн эцсээр, толгойгоор



## Газар тариалан

*Тариалалт*

2016 оны тариалалтын эцсийн мэдээгээр 51.2 га талбайд тариалалт хийснээс төмс 22.9 га-д, хүнсний ногоо 18.2 га-д, тэжээлийн ургамал 10.6 га-д тариалсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт тариалсан талбай 25.3 га буюу 97.7 хувиар их байгаагаас төмсний талбай 14.6 га буюу 2.7 дахин, тэжээлийн ургамлын талбай 8.8 га буюу 7.3 дахин, хүнсний ногооны талбай 2 га буюу 12.3 хувиар нэмэгдсэн байна.

*Ургац хураалт*

Ургац хураалтын эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд 97.7 тн төмс, 117.4 тн хүнсний ногоо хурааж, 1434.5 тн өвс бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс төмс 48.3 тн-



оор буюу 97.8 хувиар, хүнсний ногоо 15.4 тн-оор буюу 13.9 хувиар, бэлтгэсэн өвс 301.7 тн-оор буюу 26.6 хувиар тус тус өссөн байна.




### VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны байдлаар 47063.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 9504.1 сая төгрөг буюу 25.3 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарын гаргалт нь 9412.3 сая төг буюу 26.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 44724.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5672.0 сая төгрөг буюу 14.5 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 95.6 хувь буюу 42.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Зураг VIII.1

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар,  
Жилийн эцэс, сая төгрөгөөр



### IX. ТЭЭВЭР

Авто тээврийн үндэсний төвийн 2016 оны мэдээгээр 23.7 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 5355.2 мян.хүн км болж, 11 ажилтантай 14.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал зорчигч тээвэрлэлт 8.0 хувиар, зорчигч эргэлт 1.0 хувиар, тээврийн орлого 17.2 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарлаа.




## Х. ХОЛБОО

Аймгийн холбооны газрын мэдээгээр 2016 онд нийт орлого 202.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 17.7 сая төг буюу 8.0 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 121.6 сая төг буюу 60.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт суурин телефон цэгийн тоо 334 болж өмнөх оны мөн үеийнхээс 64 буюу 16.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны 12 сарын байдлаар интернет үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 270 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 77 байна.

Зураг Х.1

Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого, жилийн эцсийн байдлаар , мянган төгрөгөөр



## XI. Цаг агаарын мэдээ

□□□ □□□□□□□□: Энэ сард нийт 0.2 мм хур тунадас орсон.

□□□□□: Ихэнх хугацаанд секундэд 3-8 метр байсан.

□□□□□□ □□□□□□□□□□: 12-р сарын 1-р арав хоногийн дунд үеэр шөнөдөө 14-19 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус хүйтэн, 2-р арав хоногийн сүүлээр болон 3-р арав хоногийн эхэн болон дунд үеэр шөнөдөө 16-21 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус хүйтэн, бусад хугацаанд шөнөдөө 11-16 градус хүйтэн, өдөртөө 4 градус хүйтнээс 1 градус дулаан байсан. Хамгийн дулаан нь 1-ний өдөр 1.8 градус дулаан, хамгийн хүйтэн нь 30-ны шөнө 24.6 градус хүйтэн байсан байна.





## **НЭГДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ**

Энэ сарын агаарын температурын дундаж нь ихэнх нутгаар 15-20 градус хүйтэн байх бөгөөд ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн сүүлчээр хүйтний эрч суларч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 17-22 градус, өдөртөө 4-9 градус хүйтэн байна. Харин нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч чангарч шөнөдөө 24-29 градус, өдөртөө 12-17 градус хүйтэн байна. Бусад хугацаанд шөнөдөө 18-23 градус өдөртөө 7-12 градус хүйтэн байна.

Энэ сард Говьсүмбэр аймагт олон жилийн дунджийн орчим цас орох төлөвтэй

Нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар, нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр нутгийн хойд хэсгээр, гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн зүүн хэсгээр цас орж, цасан шуурга шуурах төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёр ба гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.



## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд</b>				
Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)	хүн	442	446	100.9
Ажил хайгч иргэдийн тоо, 12 дугаар сарын эцэст	хүн	332	238	71.7
Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо	хүн	115	292	2.5 дахин
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	211	207	98.1
<b>Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт</b>				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	14467.0	15701.4	108.5
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	14929.2	14687.1	98.4
Авлага	сая.төг	18.2	12.3	67.6
Өглөг	сая.төг	302.7	27.9	92.2
Том малын зүй бусын хорогдол	<u>тол</u>	1987	14686	7.4 дахин
Төллөсөн хээлтэгч	<u>тол</u>	140877	157213	1111.6
Бойжуулсан төл	<u>тол</u>	139735	153066	109.5
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт гаргалт	сая.төг	37559.5	47063.6	125.3
Тээврийн орлого	сая.төг	12.1	14.2	117.2
Холбооны орлого	сая.төг	220.1	202.4	91.9



## I.1 ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}} \%$
Ажил хайгч <u>иргэнийн</u> тоо	332	238	71.7
Үүнээс эмэгтэй	187	130	69.5
Ажлын байрны захиалга	535	151	28.2
Ажилд <u>жуучлагдсан</u> иргэд	300	49	16.3
Үүнээс эмэгтэй	171	29	17.0

## II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сангийн төрөл	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}} \%$
<b>Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг</b>	<b>6685.1</b>	<b>7583.6</b>	<b>113.4</b>
Тэтгэврийн даатгалын сангийн	4436.5	4747.9	107.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	425.7	527.1	123.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1177.6	1414.3	120.1
<u>ҮОМШӨ*</u> -ний даатгалын сангийн	526.6	736.9	139.9
<u>Ажилгүйдлын</u> даатгалын сангийн	118.8	157.5	132.6
<b>Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг</b>	<b>8600.6</b>	<b>9385.3</b>	<b>109.1</b>
Тэтгэврийн даатгалын сангийн	6146.3	6781.5	110.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	591.9	569.5	96.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1349.3	1527.6	113.2
<u>ҮОМШӨ*</u> -ний даатгалын сангийн	312.5	287.5	92.0
<u>Ажилгүйдлын</u> даатгалын сангийн	200.6	219.2	109.3

Тайлбар: \*ҮОМШӨ –Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, 2016 оны 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 XII		2016 XII		$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}} \%$	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
<b>Нийгмийн халамжийн сангийн дүн</b>	4508	1225.3	4724	1259.7	104.8	102.8
<b>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж</b>	1484	784.4	1526	814.5	102.8	103.8
Халамжийн тэтгэвэр	307	384.4	338	389.2	110.1	101.2
Нөхцөлт мөнгөн тэтгэмж / Үүнээс: /	1177	399.9	1188	425.3	100.9	106.3
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	872	210.5	861	211.4	98.7	100.4
Ахмад настныг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	140	69.3	152	79.7	108.6	115.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	140	102.7	153	119.2	109.3	116.1
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсөн, асарч буй иргэний тэтгэмж	25	17.4	22	14.9	88.0	85.6
<b>Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж</b>	3024	440.8	3198	445.2	105.8	101.0
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	1321	79.8	734	76.1	55.6	95.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	220	52.8	293	70.1	133.2	132.8
Нийгмийн халамжийн үйлчилгээ	48	57.9	470	49.6	9.8 дахин	85.7
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	250	69.0	497	72.9	198.8	105.7
Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	20	19.5	7	12.9	-2.9 дахин	66.2
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1165	161.8	1197	163.5	102.7	101.1



## III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
Төрсөн эх	442	446	100.9
Амьд төрсөн хүүхэд	446	450	100.9
Эрэгтэй	212	222	104.7
Эмэгтэй	234	228	97.4
Амьгүй төрөлт	2	2	100.0
Нийт нас баралт	81	73	90.1
Эмнэлгийн нас баралт	11	14	127.3
Хоног болоогүй нас баралт	4	8	2 дахин
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	6	7	116.7
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	7	9	128.6
Эмчлэгдсэн өвчтөн	4568	5023	110.0
Амбулаторийн үзлэг	119733	122060	101.9
Халдварт өвчин	115	292	2.5 дахин



## IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , төрлөөр

Үзүүлэлт	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг</b>	<b>211</b>	<b>207</b>	<b>98.1</b>
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	92	91	98.9
Өмчлөх эрхийн эсрэг	74	73	98.6
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	13	9	69.2
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	13	68.4
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	4	7	175
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	8	800
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	6	-	-6 нэгж
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	1	100.0
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	2	200.0
Албан тушаалтны эсрэг гэмт хэрэг	0	2	2 нэгж
Иргэдийн улс төрийн болон бусад эрх эрх чөлөөний эсрэг гэмт	1	1	100.0
<b>Гэмт хэрэгт холбогдогсод</b>	<b>223</b>	<b>218</b>	<b>97.7</b>
15 хүртэлх насны	1	1	100.0
16-17 насны	8	8	100.0
18-29 насны	75	103	137.3
30-34 насны	34	38	111.8
35-с дээш	105	68	64.8
Боловсрол – Дээд	44	41	93.2
Боловсрол - Тусгай дунд	14	24	171.4
Боловсрол – Бүрэн дунд	82	84	102.4
Боловсрол – Бүрэн бус дунд	56	37	66.1
Боловсрол – Бага	21	24	114.3
Боловсролгүй	6	7	116.7
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	19	8	42.1
Ажилгүй иргэд үйлдсэн	88	96	109.1
Эмэгтэй хүн оролцсон	34	35	102.9
Хүүхэд оролцсон	8	8	100.0
Бүлгээр үйлдсэн	29	36	124.1
Согтуугаар үйлдсэн	103	85	82.5
<b>Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал</b>	<b>211</b>	<b>207</b>	<b>98.1</b>
Гудамж талбайд	57	60	105.3
Албан газарт	19	31	163.2
Гэр орон сууцанд	65	61	93.8
Авто зам	18	11	61.1
Бусад газарт	47	42	89.4
ГХ-н улмаас нас барсан	22	29	131.8
ГХ-н улмаас гэмтсэн	244	175	71.7
Учирсан хохирол / сая.төг /	1164	472	40.5
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	469	306	65.2



## VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}} \%$
<b>Орон нутгийн орлого</b>	<b>14467.0</b>	<b>15701.4</b>	<b>108.5</b>
Татварын орлого	3936.0	4796.9	121.9
Орлогын албан татвар	2786.0	3256.4	116.9
Өмчийн татвар	223.0	348.9	156.4
Дотоодын бараа үйлчилгээний	-	-	-
Бусад	831.1	1185.8	142.7
Татварын бус орлого	353.0	902.2	255.6
Хөрөнгийн орлого	0.7	5.9	8.4 дахин
Тусламжийн орлого	10177.3	10002.3	98.3

## VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}} \%$
<b>Бүх зарлага</b>	<b>14929.2</b>	<b>14687.1</b>	<b>98.4</b>
Бараа үйлчилгээний зардал	10736.8	11140.0	103.8
Нийгмийн халамжийн үйлчилгээний зардал	1039.5	1081.1	104.0
Хөрөнгийн зардал	3152.9	2465.9	78.2
Төсөвт байгууллагын тоо	47	47	100.0
Төсөвт байгууллагын ажиллагсдын тоо	751	751	100.0

## VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}} \%$
Авлага	18.2	12.3	67.6
Өглөг	302.7	27.9	92.2



## VIII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Төрөл	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Бүгд</b>	<b>140877</b>	<b>157213</b>	<b>111.6</b>
Ингэ	185	253	136.8
Гүү	4684	5121	109.3
Үнээ	4296	4866	113.3
Эм хонь	65609	74922	114.2
Эм ямаа	66103	72051	109.0

## VIII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумд	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Дүн</b>	<b>140877</b>	<b>157213</b>	<b>111.6</b>
<u>Баянтал</u>	25305	24384	96.4
Сүмбэр	98457	115955	117.8
<u>Шивээговь</u>	17115	16874	98.6

## VIII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Төрөл	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Бүгд</b>	<b>139735</b>	<b>153066</b>	<b>109.5</b>
Ботго	174	241	138.5
Унага	4632	5038	108.8
Тугал	4231	4712	111.4
Хурга	65235	73720	113.0
Ишиг	65463	69355	105.9

## VIII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумд	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Дүн</b>	<b>139735</b>	<b>153066</b>	<b>109.5</b>
<u>Баянтал</u>	25805	24277	94.1
Сүмбэр	96531	112486	116.5
<u>Шивээговь</u>	17399	16303	93.7





## VIII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Төрөл	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Бүгд</b>	<b>1987</b>	<b>14686</b>	<b>7.4 дахин</b>
Тэмээ	7	6	85.7
Адуу	58	397	6.8 дахин
Үхэр	77	505	6.5 дахин
Хонь	858	5078	5.9 дахин
Ямаа	987	8700	8.8 дахин

## VIII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумд	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Дүн</b>	<b>1987</b>	<b>14686</b>	<b>7.4 дахин</b>
<u>Баянтал</u>	106	2481	23.4 дахин
Сүмбэр	1677	8650	5.2 дахин
<u>Шивээговь</u>	204	3555	17.4 дахин

## VIII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Төрөл	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Бүгд</b>	<b>393</b>	<b>5468</b>	<b>13.9 дахин</b>
Тэмээ	-	-	-
Адуу	4	257	64.2 дахин
Үхэр	11	216	19.6 дахин
Хонь	162	2143	13.2 дахин
Ямаа	216	2852	13.2 дахин

## VIII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумд	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
<b>Дүн</b>	<b>393</b>	<b>5468</b>	<b>13.9 дахин</b>
<u>Баянтал</u>	29	424	14.6 дахин
Сүмбэр	319	2176	6.8 дахин
<u>Шивээговь</u>	45	2868	63.7 дахин



## VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт жил бүрийн эхний 12 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
Нийт	37559.5	47063.6	125.3
Уул уурхайн нийт гаргалт	35698.9	45111.2	126.4
Сувагжуулалт	67.0	77.3	115.4
Дулаан	1624.8	1689.1	104.0
Усан хангамж	168.8	186.0	110.2

## VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 12 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
Нийт	39052.6	44724.6	114.5
Уул уурхай	37192.0	42772.1	115.0
Дулааны эрчим хүч, усан хангамж, сувагжуулалт	1860.6	1952.5	104.9
Дулаан	1624.8	1689.1	103.9
Цэвэр ус	168.7	186.0	110.3

## VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний нийт үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
Нийт борлуулалт /Үнийн дүнгээр, сая.төг/	37192.0	42772.1	115.0
Нүүрс борлуулалт /биет хэмжээ, мян.тн/	1823.4	1880.3	103.1
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	1772.9	1961.4	110.6
Ажиллагсдын тоо	515	595	115.5



## IX.1 Авто тээврийн газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлт	Нэгж	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
Тээврийн орлого	Мян.төг	12112.1	14200.0	117.2
Зорчигч эргэлт	Мян.хүн км	5304	5355.2	101.0
Зорчигчдын тоо	Мян.хүн	22.1	23.87	108.0
Ажиллагсдын тоо	тоо	10	11	110.0

## X.1 Аймгийн холбооны газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлт	нэгж	2015 XII	2016 XII	$\frac{2016 \text{ XII}}{2015 \text{ XII}}\%$
Нийт орлого	мян.төг	220165.1	202478.0	92.0
Үүнээс: Хүн амаас	мян.төг	121529.6	121583.6	100.0
КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	тоо	1272	1233	96.9
Телефон цэг	тоо	398	334	83.9

E-майл хаяг:

[govisumber@nso.mn](mailto:govisumber@nso.mn)

Вэб хаяг:

[govisumber.nso.mn](http://govisumber.nso.mn)

Мэдээллийн сангийн хаяг:

[www.1212.mn](http://www.1212.mn)

Утас:

70543222, 70543017